



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Иргэдэд үйлчлэх төв байр, Чингисийн өргөн чөлөө,
20 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042

Утас: 7777-1965, Факс: (976-11) 34-44-77

E-mail: info@khanuul.mn

<http://www.khanuul.mn>

2020.10.26

№ 07/1875


танай _____-ны № _____-т

「 ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХЭЛТЭС, АЛБАДЫН
ДАРГА НАРТ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020 оны 02 дугаар “Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ үү.

Хавсралт Нийслэлийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн албан даалгаврын хуулбар 3 хуудастай

ДАРГА



Б.ЭНХБОЛД



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Хүүхдийн тоглоомын талбайн MNS 6751:2019 стандартын хэрэгжилтийг хангаж, хүүхдийг болзошгүй аюул осолд өртөхөөс урьдчилан сэргийлж, тэднийг эрүүл аюулгүй орчинд өсөж бойжих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор төрийн бүх байгууллага, аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэдэд ДААЛГАХ нь:

1. Хүүхдийг авто замын ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачаалал ихтэй гарц дээр олон нийтийн цагдааг эргүүлээр ажиллуулах, замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарын хариуцлагыг өндөржүүлж явган зорчигчдод зам тавьж өгөх дүрмийг мөрдүүлж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/, Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба /Д.Дашдорж/, дүүргийн Засаг дарга нарт;

2. Хүүхдийн эрхийг хамгаалахад олон нийт, эцэг эх, асран хамгаалагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Би хариуцлагатай аав ээж" аяныг эрчимжүүлж, хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах, Хүүхдийн тусламжийн "108" утсыг олон нийтэд сурталчлан таниулж ажиллахыг Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ө.Ган-Өлзий/-т;

3. Хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Гараас гарт дамжуулах" хөтөлбөр, "School police" арга хэмжээг эрчимжүүлэх, бүх шатны боловсролын байгууллагын багш, нийгмийн ажилтан, удирдах ажилтан болон эцэг эхчүүдэд бага насны хүүхдийн ахуйн болон зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохируулан замын хөдөлгөөнд оролцох дүрмийн мэдлэгийг олгох сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/-т;

4. Сургуулийн нийгмийн ажилтнууд, анги даасан багш нар хүүхэд бүрийн ар гэрийн байдлыг анхаарах, эцэг эхтэй уулзаж, өвчтэй, чөлөөтэй, хичээл тасалсан, шалтгаангүйгээр хоцорсон зэрэг асуудлыг тогтмол нягталж тодруулах, сургуулийн эмч нар хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийг хийхдээ биед ямар нэгэн зодуур, гэмтэл бэртэл, эрсдэл бүхий шинжүүд байгаа эсэх, сэжигтэй тохиолдлыг шалгах, хүчирхийллийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллахыг Нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/-т, хүүхдийн хүчирхийллийн шинж тэмдгийг танин мэдэх сургалтад хороодын хэсгийн ахлагч нарыг хамруулж, үйл ажиллагаандаа

111020000006

хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ө.Ган-Өлзий/, дүүргүүдийн Засаг дарга нарт;

5. Сургууль, цэцэрлэг, өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаа, түүний орчинд үйл ажиллагаа явуулж байгаа цайны газар болон үйлчилгээний байгууллагуудад хяналт шалгалт зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т;

6. Эрүүл мэндийн байгууллагад ахуйн гэмтлээр ирсэн хүүхэд, эмэгтэйчүүд болон ар гэрийг сэтгэц, зан үйл, хүүхэд асран хамгаалах чадамжийн талаарх сорилд хамруулж, сэжигтэй тохиолдлыг хууль, хяналтын байгууллагад мэдэгдэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ө.Ган-Өлзий/-т;

7. Зам тээврийн осол ихээр гарч байгаа байршлыг тогтоон, явган хүний гүүрэн гарцыг стандартын дагуу барих, бусад шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулж судлан танилцуулахыг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар /Ц.Тулга/, Нийслэлийн Замын хөдөлгөөн төлөвлөлт, зохицуулалт инженерчлэлийн газар /С.Энхтөр/, Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба /Д.Дашдорж/, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Г.Баттогтох/-т;

8. Хүүхдийн тоглоомын талбайн MNS6751:2019 стандартын хэрэгжилтийг хангуулах, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бий болгох, золбин нохой, муурыг устгах ажлыг эрчимжүүлж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Л.Гантөмөр/, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар /С.Төмөрдулам/, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ө.Ган-Өлзий/, дүүргийн Засаг дарга нарт;

9. Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртсөн хүүхдэд шаардлагатай үйлчилгээг шуурхай үзүүлэх, гэр бүлтэй нь ажиллах, дэмжих бүлэг байгуулах, гэрийн тэжээвэр амьтны хараа хяналтыг сайжруулах, хөршийн хяналтын тогтолцоог бий болгох, бүх шатны Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ө.Ган-Өлзий/, дүүргийн Засаг дарга нарт,

10. Шахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, зөв хэрэглээг төлөвшүүлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн хараа хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн талаар хэлэлцүүлэг хийх, зөвлөгөө мэдээллийг түгээж ажиллахыг Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ө.Ган-Өлзий/, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/, Нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/-т;

11. Хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээлэл өгсөн иргэний мэдээллийг нууцалж, тухайн иргэнд хүндрэл учруулалгүйгээр шийдвэрлэж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/-т;

12. Агаарын бохирдолтой тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа төрийн албан хаагчдад хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар чиглэл өгч хамтран ажиллахыг Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ө.Ган-Өлзий/-т;

13. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг 14 хоног тутам гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад, хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Уртнасан/, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Л.Гантөмөр/-нд, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, уриалга гаргаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /М.Батбаатар/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР
ОРЛОГЧ



Ж.БАТБАЯСГАЛАН

ИЛГЭЭХ БАЙГУУЛЛАГА

2020 оны 10 дугаар сарын 21

Улаанбаатар хот

№	Байгууллагын нэр	Илгээх төрөл
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	Системээр
2	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс	Системээр
3	Цагдаагийн газар	Системээр
4	Боловсролын хэлтэс	Системээр
5	Эрүүл мэндийн төв	Системээр
6	Замын цагдаагийн хэлтэс	Цаасаар
7	Мэргэжлийн хяналтын хэлтэс	Системээр